

“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04-р сарын 04-ний өдөр

Дугаар:18/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын заланд 2018.04.04-ний өдрийн 16.00 цагт болов.

“Хүрд “ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн нарийн бичгийн дарга Г.Гантуяа хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга О.Шинэхүүг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Шинэхүүгийн танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 110,041.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 96 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д "Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно" гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Б.Энхжаргалын итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Ундрах, Д.Дашдорж, Б.Мөнхбат, Ц.Эрдэнэсүх, Г.Алтансүх, Б.Бат-Эрдэнэ, Л.Цэрэндондог, С.Мягмарсүрэн, “Би Ди Сек ҮЦК” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Билгүүн нарын 9 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө, 2018 оны удирдлагын зардлыг батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
5. Бусад асуудлын хүрээнд компанийн аудитын байгууллагыг сонгон танилцуулах

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Үндэсний шуудан/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2017 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоо, ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчидтэй та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, зарим нь брокерийн компаниудад хүргүүлсэн материалтай танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж. Компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлттэй танилцлаа. 2017 оны үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилт биелж, 3,8 тэрбум төгрөгийн борлуулалт, 611,1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Барилга угсралтын ажлын хувьд 334 сая төгрөг, түрээсийн ашиг 72,6 сая, банкны хадгаламж, харилцахын хүүгийн ашиг 121,5 сая төгрөг, компанийн хэмжээнд ашигт ажиллагааны түвшин 16,63% байна.

Ногдол ашигт нэгж хувьцаанд 497 төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Ногдол ашгийн хэмжээ урьд оныхоос буурсан ч олгож байгаад нь хувьцаа эзэмшигчийн хувьд баяртай байна. Удирдлагын зардал төлөвлөснөөс хэтэрсэн байна. ТУЗ-ийн дүгнэлтээс харахад мэргэжилтэй ажилтнуудыг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд 6 удаагийн сургалтад 14,24 сая төгрөг зарцуулсан байна. Бизнес төлөвлөгөөний борлуулалтын орлого нэмэгдсэн ч ашгийн хэмжээ буурсан байна.

Ажилтнуудын дундаж цалин 30%-аар өссөн нь барилга угсралтын ажил их, сул зогсолт бага байсантай холбож ойлголоо. Хийгдсэн ажлын үр дүнгээр удирдлагын урамшууллыг олгожээ.

Барилга угсралтын ажлыг гүйцэтгээд олж авч чадаагүй байгаа 1,0 тэрбум төгрөгийг олж авах талаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байгаа юм байна. Орон сууц барих асуудлыг дэмжиж байна.

“Хүрд-Нарлаг” ХХК алдагдалтай ажилладаг байсныг үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж Барилгачин сувилал болгон ашигтай ажиллаж эхэлсэнд талархаж байна.

Төмөр хийцийн цех, бетон эдлэлийн цехийн бие даасан үйл ажиллагааг жигдрүүлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй ажилтнаар хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Орон сууц ашиглалтын үйл ажиллагаа мөн хэвийн явагдаж байгаа юм байна. Ашиглалтгүй байсан цехүүдийн барилгыг спорт зал болгон тохижуулж, ажилтнуудаа чөлөөт цагаараа спортоор хичээллэх боломж олгосон нь сайшаатай байна.

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Л.Цэрэндондог. Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, ашигтай ажилласан байна. Ногдол ашгийн бага зэрэг буурсан нь ашиг буурсантай холбоотой биз ээ. Эдийн засаг хүндрэлтэй байгаа 2018 онд ч боломжийн зорилт дэвшүүлсэн байна. “Хүрд Нарлаг” ХХК-ийг ашигтай ажиллуулж эхэлсэн нь сайн байна. Засгийн газрын бонд худалдаж авах, материалын худалдаа эрхэлж ашиг олох тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Эрдэнэ: Орон сууц ашиглалтын талаар саналаа хэлэхэд ашиглалтад орсон болон орох орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ, дотор сантехник, цахилгаан, холбооны зургийн иж бүрдлийг бүрдүүлж авах хэрэгтэй гэж бодож байна. Бид цаашид ашиглалтын үйл ажиллагаа

эрхлэхэд зураг зайлшгүй хэрэгтэй. Иймээс зураг төслийн тусгай зөвшөөрөл авч залуу инженерүүд ажилд аваад байгаа. Энэ инженерүүд маань баригдаж байгаа орон сууцны зургийн өөрчлөлтийг хийж сайн ажиллаж байгаа.

Надад хоёр хүсэлт байна.

1. Компани 98 айлын орон сууц барьж байгаа. Энэ жил ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байгаа. Байрны үнийн асуудлыг шийдэх хэрэгтэй байна. Компанийн ажилтнуудад ямар үнээр борлуулах, гадагш ямар үнээр борлуулах вэ гэдгийг шийдмээр байна. Жишээ нь 30 жил ажилласан надад ямар хөнгөлөлт байх юм? Надтай адил олон жил ажилласан хүмүүс байгаа. Энэ талаар шийдвэр гаргах хэрэгтэй. Захирлын зөвлөлийн хурлаас санал гаргаж ТУЗ-д танилцуулах эрх олгохыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас хүсч байна.
2. Цалингийн асуудлыг авч хэлэлцэх цаг болжээ. Инфляцитай уялдуулж байх хэрэгтэй байна.

2018 оны үйл ажиллагааны ноён нурууг босгож чаджээ. Тодорхой төлөвлөсөн ажлууд байна. Бид 2018 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. ТУЗ-ийн тайлан, 2018 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Би Ди Сек ХХК /Б.Билгүүн/ Энэ жил орон сууц ашиглалтад оруулна гэж байна. Барилга барих хөрөнгө нь хаана байгаа юм. Орон сууцаа ямар хөрөнгөөр, ямар компаниар бариулж байгаа вэ? Орон сууцны 1м²-ийн өртөг хэдэн төгрөг байгаа вэ.

Хурлын дарга Б.Мөнхбат: Орон сууцыг өөрийн хөрөнгөөр барьж байгаа, цаашид борлуулалтын орлогоор барина. Бетон зуурмагаа өөрийн Бетон эдлэлийн үйлдвэрт үйлдвэрлэж байгаа. Нэгэнт эхэлсэн орон сууцаа ямар ч байсан дуусгана. Гадаад зах зээлд төмрийн үнэ нэлээд өсч байна.

Илтгэлийн талаар тайлбар өгье гэж бодож байна. 2017 онд гүйцэтгэсэн 4231,7 сая төгрөгийн барилга угсралтын ажлын 1088,0 сая нь орон сууцны барилгын ажил юм. Гэхдээ энэ ажлыг бид өөрийн хөрөнгөөр дотооддоо гүйцэтгэсэн тул улсад мэдээлээгүй ажил юм. Мөн 1177,87 сая төгрөг нь орон сууц ашиглалтын орлого юм. Эдгээр барилга угсралтын ажлаас бид 334,0 сая төгрөгийн ашигтай ажилласан нь барилга угсралтын ажлын хувьд ашиг 10%-д ч хүрээгүй болно. ашигтай ажилласан. Төсөвт 15% ашиг тусгагддаг боловч 10% ашигтай гарсан. 2017 онд Компани 2017 онд Азийн хөгжлийн банк, болон улс, хотын хөрөнгөөр санхүүжих 31 тендерт оролцсоноос **3,1 тэрбум** төгрөгийн өртөг бүхий 7 тендерт шалгарч гэрээт ажлыг гүйцэтгэсэн болно.

Орон сууц ашиглалтын конторын хувьд: бид урьд нь шинэ юм хийж хүлээлгэж өгдөг байсан тул энэ жилээс анх удаа хүний хийсэн юмыг ашиглаж үзлээ. Хүйтний улиралд ачаалал ихтэй үед айл өрхөөс авсан дулааны мөнгөнөөс ашиг гарахгүй, УБДС ТӨХК-д шилжүүлээд л таарах юм байна. Эрчим хүчний

зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд тохиролцоонд хүрч тодорхой хувь нь үлдэх байх. Одоо тусгай зөвшөөрлөө авах хүсэлтээ гаргаад байгаа.

Азийн хөгжлийн банк, Европын Хөрөнгө оруулалтын банкны хөрөнгөөр санхүүжих Улаанбаатар хотын Сэлбэ дэд төвийн дулааны станцын угсралтын 6,7 сая америк долларын өртөгтэй ажлын тендерт 2016 онд оролцож, 2017 оны 07-р сард ажил гэрээ гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд одоогоор барилга угсралтын ажил зураг төслийн шатанд яваа. 2018 онд цахилгааны 2х1000кВА трансформатортай хаалттай дэд өртөө барих, зуухны барилга барих, зуух суурилуулах ажлыг гүйцэтгэж, нийт ажлын 50% гүйцэтгэх төлөвлөгөөтэй байгаа.

- Дархан хотын дулааны насос станц №3-ын шинэчлэлт, цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамын 1,0 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгөх үүрэг хариуцлага оногдож байна.

Б.Бат-Эрдэнийн саналыг ТУЗ-д танилцуулж шийдүүлэх боломжтой юм.

Хувьцаа эзэмшигч Л.Цэрэндондог. Олон жил ажилласан хүмүүст орон сууцны хөнгөлөлт үзүүлэх саналыг дэмжиж байна.

Хурлын дарга Б.Мөнхбат: Та бүхний санал, дүгнэлтийг сонслоо. Одоо ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалдаа орье. Компанийн 2012 оны шинэчилсэн дүрмийн 7.18-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ” гэж заасан байгаа. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаа тул ТУЗ-ийн гишүүдийн сонгууль явагдаж байна. ТУЗ-ийн гишүүдэд компанийн засаглалын сургалтад хамрагдсан, энэ компанид одоо ажиллаж байгаа, хувьцаа эзэмшигч хүмүүсийг нэр дэвшүүлсэн байгаа. Танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн. Энэ хүмүүстээ хүн тус бүр дээр санал хураагаад явья.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн даалгаварт:

- “Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулахаар заана” гэж заасантай нийцүүлж 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дүрмэндээ нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах
- Мөн хуулийн 94,3-д “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална гэж заасан байгаа.

Компанийн 2012 онд шинэчлэн батлуулсан дүрмийн 9.6-р зүйлд “Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний

үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулна” , 9.7-д “Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ” гэж заасан.

Иймд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын байгууллагуудтай танилцаад “Бест Фортуна Аудит” ХХК аудитын байгууллагыг сонгож батлахуулахаар оруулж байна.

“Бест Фортуна Аудит” ХХК аудитын байгууллагын үйл ажиллагаатай та бүхэн танилцаж баталж өгнө үү.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2017 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2018 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, аудитын байгууллага сонгох санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга Ж.Дүгэржав санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **110,860.0** ширхэг хувьцаа буюу **99,84** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **110,860.0** ширхэг хувьцаа буюу **99,84** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
3. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө, 2018 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **110,860.0** ширхэг хувьцаа буюу **99,84** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **110,859.0** ширхэг хувьцаа буюу **99,84** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
5. Бусад: Компанийн тухай хуулийн 94,3-т “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/

аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална” гэж заасны дагуу “Бест Фортуна Аудит” ХХК аудитын байгууллагыг сонгож батлах” хэлэлцэж баталсан **100,206.0** саналын тоо **90,24 %**.

ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дахин сонгов.
5. “Бест Фортуна” ХХК аудитын байгууллагыг сонгов.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.30 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН

ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.ГАНТУЯА